НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

# ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНООС 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 03.

Улаанбаатар хот

| № | ҮЙЛ АЖИЛЛАГАА | БИЕЛЭЛТ | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хорооны хуралдаан | Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэв.<br>Ёс зүйн хэсгийн хорооноос хийсэн хурлын тоо - 4<br>Авч хэлэлцсэн асуудал -5, 100% шийдвэрлэв.<br>Нийт шийдвэрлэсэн асуудлын тоо - 5<br>Үүнээс: 2024 оны төлөвлөгөө - 1<br>1. ЭМЯ-ны шагналд нэр дэвшигчдийн ёс зүйн дүгнэлт<br>2. Ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэхээр хуралдсан.<br>3. Ёс зүйн хэсгийн хороонд ирсэн 4 гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж иргэнд хуулийн хугацаанд хариуг өгсөн.<br>Нийт 4 гомдлын 2 нь үндэслэлгүй байсан. 1 гомдлыг төрийн албан хаагчийн болон эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрмийг уншиж судлуулж шалгалт авсан. Тухай сарын ажил дүгнэх үзүүлэлтээс хасуулсан.<br>2 ажилтных үндэслэлгүй байсан тул иргэнд хариуг мэдэгдсэн.<br>1 их эмчийн гомдол Ёс зүйн хэсгийн хорооноос дүгнэлт гаргаж удирдлагын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн сахилгын шийтгэл ноогдуулсан.<br>4. Түргэн тусламжийн төвийн 18 ажилтныг Засаг даргын А/881 дүгээр тушаалын дагуу урамшуулахад ёс зүйн талаас зөрчил гаргаагүй талаар хэлэлцсэн. | | | |
| 2 | Ёс зүйн талаар сургалт | Эмч эмнэлгийн дээд мэргэжилтэн | Эмнэлгийн тусгай мэргэжилтэн | Бусад эмнэлгийн мэргэжилтэй ажилчид | Иргэд |
| | - 2024 онд тус төвийн эмч ажилчдад ёс зүй харьцаа хандлагын дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1. 2024 онд тус төвийн эмч ажилчдад ёс зүй харьцаа хандлагын 3 удаагийн 4 цагийн сургалтад 410 ажилтан хамрагдсан. Үүнд: | - 266 | - 31 | - 113 | |
| | 2. Эмнэлгийн ажилтны ёс зүй харьцаа хандлагын үйлчлүүлэгчтэй харилцах талаар 3 өдрийн 3 цагийн вакумжуулсан сургалтыг төвийн үйлдвэрчний хороотой хамтарч зохион байгуулсан. Нийт 410 хамрагдсан. Үүнд: | - 261 | - 31 | - 118 | |
| |   | | | | |
| | 3. Ажлын байрны ёс зүй сургалтад 328 ажилтан албан хаагч хамрагдсан. | - 201 | - 31 | - 96 | |
| | 4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийтлэг гаргадаг харилцаа хандлагын алдааны тохиолдолд суурилсан багийн ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулсан | - 30 | - 10 | | |
| |   | | | | |
| | 5. Шинээр ажилд орсон нийт эмч, жолооч нарт эмнэлгийн ажилтны ёс зүй, үйлүүлэгчийн эрхээр Ёс зүйн хорооны дарга Д.Дариймаа сургалт зохион байгуулсан. | - 42 | - 2 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| |  <br>6. МУЗГ-ын 2024.10.02 өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” А/109-р тогтоол, МУНЗДаргын 202.11.01 01/6176 “ Тогтоол хүргүүлэх тухай” тушаалуудыг танилцуулж, удирдах ажилтан, эмч жолооч нарт сургалт зохион байгуулсан<br>  | - 25 | - 2 | - 101 | |
| 3 | Ёс зүйн асуудлаар зохион байгуулсан үйл ажиллагаа | 1. Нийт 5 салбараас ёс зүйн хэсгийн хороог шинэчлэхээр санал авсан.<br>2. Байгууллагын вэб сайт, салбаруудын мэдээлэлийн самбарт мэдээлэлүүдийг байршуулсан.<br>3. “Эерэг хандлага түгээцгээе” өдөрлөг зохион байгуулсан. Түргэн тусламжийн үйл ажиллагааг сурталчлах эрүүл мэндийн зөвлөгөө өгч гарын авлага 200 гаруй иргэдэд мэдээлэл тараасан<br>4. ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, эмч ажилчдын харьцаа хандлага, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Ёс зүйн сарын аян”-ыг зарлаж, удирдамж, хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан. | | | |

Аяныг 2024 оны 01 сарын 15-ны өдрөөс 02 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд салбаруудын хэмжээнд нийт эмч ажилчдыг хамруулан зохион байгуулсан. Аяны хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажилласан.




Төлөвлөгөөний дагуу ЭМС-ын А/406 тоот тушаалаар сургалт зохион байгуулж, тушаалын талаар мэдлэг шалгах сорилын асуумж боловсруулж үнэлгээ хийсэн. Сургалтанд нийт эмч нар 100% хамрагдсан. Дундаж үнэлгээ 88.5%




Иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж, гарын авлага 100 ширхэгийг тараасан.

5. 2024 оны 11-р сарын 06-ны өдрийн байгууллагын удирдлагын зөвлөлийн хуралд МУНЗДарга Х.Нямбаатар 2024.11.01 01/6176 "Тогтоол хүргүүлэх тухай" МУЗГазрын 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн 109-р тогтоол "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" тогтоолуудаар мэдээлэл сургалт хийсэн.



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Эвлэрүүлэн зуучлалын хийсэн | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн тоо<br>0 | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн<br>0 | Үйлчлүүлэгч эмнэлийн мэргэжилтнүүд-ийг эвлэрүүлсэн тоо<br>0 | Ёс зүй харьцаа хандлагын гомдол гараагүй тул эвлэрүүлэн зуучлалын хийгдээгүй болно |
| 5 | Ил тод байдал | Цахим хуудсанд байршуулсан ёс зүйн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл<br>1. 2023 оны Ёс зүйн хэсгийн хорооны тайлан, 2024 төлөвлөгөө байршуулсан.<br>2. Эмч ажилчдад ирсэн нийт талархлыг 14 хоног тутам 18 удаа вэб сайтад байршуулсан.<br>3. Тус төвийн эмч, сувилагч, жолооч нарт засгийн газрын 11-11 утсаар нийт 265 талархал ирсэн. Талархал авсан ажилчдын улирлын ажил дүгнэх үзүүлэлт оруулж урамшуулал олгосон. Ирсэн талархлыг вэб сайтад байршуулсан.<br><br>12 сарын 29-ний өдөр ХУД-ийн 103 яаралтай тусламжийн 3 р ээлжийн эмч Б.Төмөр, жолооч Б.Анхбаяр нар нь дуудлагаар ирж миний хүүд тусламж үйлчилгээ үзүүлэн [illegible] шатлалын эмнэлэгт цаг алдалгүй хүргэж амь насыг нь авран хамгаалж өгсөн юм. Ажилдаа чин сэтгэлээсээ хандадаг, [illegible] үнэнч, түргэн шуурхай үйлчилгээтэй, [illegible] Та бүхний ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн өөрөөж талархал илэрхийлж байна. Эмчлүүлэгч Цэнджаргал.<br>Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №11, G240104044<br><br>Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №76, G240213028<br>6 настай хүүхэд маань маш өндөр халуурсан тул усанд оруулж байх үед анхаарал алдсаны улмаас усан дотор татаалт өгч ус залгиж амь насанд нь эрсдэл үүссэн байхад нийслэлийн ХУД-ийн түргэн тусламжийн эмч Б.Төмөрөө, жолооч Б.Анхбаяр нар түргэн шуурхай ирж анхны тусламж үзүүлж амь насыг нь аварч дараагийн шатлалын эмнэлэгт хүргэж өгсөн явдалд маш их баярлаж байна. Та бүхний ажилд өндөр амжилт хүсье. БЗД-ийн 15-р хорооны иргэн Д.Оргил<br><br>[illegible]<br><br>№289, C240528019<br>103-н жолооч Д.Алтангэрэл, эмч Д.Будханд нартаа маш их баярлалаа. Манай аавын бие муудаад түргэн тусламж дуудахад түргэн шуурхай ирж эрүүл мэндийн тусламж үзүүлж амь насыг нь аварсанд баярлалаа. Ажлын амжилт хүсье. БГД-ийн 18-р хорооны иргэн Ж.Цэрэндондог | | | |

| | | |
|---|---|---|
| 6 | Бусад ажил | 1. Тусламж үйлчилгээг сайжруулах, "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай" А/406 тоот тушаалын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ёс зүйн алдаа дутагдал гарахаас сэргийлэх зорилгоор "Алдахаас сэргийлье" өдөрлөгийг зохион байгуулсан.<br>Үр дүн: Эмч нар мэдлэгээ 30%-р нэмэгдүүлж , харьцаа хандлага ур чадвараа дээшлүүлсэн.<br>  <br>2. Австрали улсын EMS Global олон улсын байгууллагын түргэн тусламжийн эмч нарыг чадавхжуулах сургалтанд 2024.10.30-2024.11.04-ны хооронд буюу 5 хоног идэвхтэй хамрагдаж, гадаадын багш нараас туршлага, мэдлэг, харьцаа хандлагаар суралцаж, ур чавдараа нэмэгдүүлсэн.<br> <br>3. Эмч, ажилчдын дунд "3*3" сагсан бөмбөгийн тэмцээн, "Бэсрэг наадам"-ыг зохион байгуулж хамт олонч, эв нэгдэлийг нэмэгдүүлсэн.<br>  |

| | | |
|---|---|---|
| | | 4. Байгууллагын ажилчдын хүүхдүүдийн дунд "Мэргэжилдээ хүрэх зам" эссэ бичлэгийн уралдаан зарлаж түрүүлсэн хүүхдэд 1 сарын англи хэлний сургалтын эрхийн бичгийг "3*3" сагсан бөмбөгийн тэмцээн дээр гардуулж өгсөн. Эмч ажилчдын зерэг сэтгэл ханамж нэмэгдсэн.<br><br><br>5. Хүүхдийн баярыг тэмдэглэн өдөрлөг зохион байгуулан, байгууллагын ажилчдын бүх хүүхдүүд бэлэг өгсөн. Эмч ажилчдын зерэг сэтгэл ханамж нэмэгдсэн. |

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ
ДАРГА: Д.ДАРИЙМАА

НЭГТГЭСЭН:
ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.АКЕРКЕ